




2019 оны 11 дүгээр сарын 11-15

## НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 998 яаралтай дуудлагыг хүлээн авсан. Эдгээрийн 121(12.1%) галзуугийн эрсдэлд өртсөн, 839(84.0%) хачигт халдвар, 8(0.8%) боом, 7(0.7%) тарваган тахал, 4(0.4%) хумхаа, 1(0.1%) ям, 5(0.5%) денги, 10(1.0%) бэтэг, 3(0.3%) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

### 1.1 Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол

Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 121 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7%-иар нэмэгдсэн байна.




Эпидемиологийн 45 дугаар долоо хоногтой харьцуулахад 6 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.




## 1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 839 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.4%-иар буурсан байна.



Эпидемиологийн 45 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар ХР-ын 672 сэжигтэй тохиолдлын 135(20%), ХБ-ын 76 сэжигтэй тохиолдлын 17(22.3%), ХЭ-ын 91 сэжигтэй тохиолдлын 18(19.7%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан.

## 1.3 Бэтэг өвчний сэжигтэй тохиолдол

Энэ долоо хоногт Завхан аймгийн Баянтэс сум, нийслэлийн БЗД, ХУД-ээс бэтэг өвчний онош тодруулахаар 3 хүний шинжилгээний материал хүлээн авч, лабораторийн шинжилгээ эхлээд байна. Он гарсаар Баянхонгор, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн 4 сум, нийслэлийн 2 дүүргээс бэтэг өвчний сэжигтэй 10 тохиолдол бүртгэгдсэн.

## 1.4 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол

Нийслэлийн СБД-ээс хумхаа өвчний онош тодруулахаар 1 хүний шинжилгээний материалыг шинжлэхэд сорьцод хумхаа өвчний үүсгэгч тодорхойлогдоогүй байна.

## 1.5 Мэрэгч амьтны дуудлага



Энэ долоо хоногт нийслэлийн СХД “Эмээлт” АТШН товчооноос ирүүлсэн мэрэгч амьтны (тулам 2 ш) хоёр удаагийн дуудлаганд үйлчилж, эрсдэлийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээ хийсэн. Сорьц материалыг шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна. Он гарсаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 103 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн.

## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

### Олон улсад:

#### Эбола вирус халдвар:

2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй тохиолдол 3285 тохиолдол бүртгэгдсэнээс 2191(67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1852(56%) нь эмэгтэйчүүд, 930(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна. ЭМБ-ын 163(5%) ажилчид халдвар авсан байна.



Зураг 2. Эбола вирус халдварын тархалт, БНАКонго улс

Эх сурвалж: ДЭМБ

### Гахайн сонгомол мялзан өвчин:

Бразил улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 05-нд Пиауи мужид гахайн сонгомол өвчнөөр 7 гахай өвчилж үхсэн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

### Баруун нилийн халуурал өвчин:

Франц улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 29-нд Bouches-Du-Rhône-д баруун нилийн халуурал өвчнөөр 1 адуу өвчилсөн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

### Хэл хөхрөх өвчин:

Белги улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 29-10-нд Льеж тосгонд хэл хөхрөх өвчнөөр 127 үхэр өртөмхий байснаас, 1 үхэр өвчилсөн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

## Африкийн гахайн мялзан өвчин:

| Эх сурвалж | Хаана                                                                                  | Мэдээлсэн хугацаа | Өртсөн хугацаа | Нэгж | Өвчилж үхсэн   | Устгасан       |
|------------|----------------------------------------------------------------------------------------|-------------------|----------------|------|----------------|----------------|
| ДМАЭМБ     | <ul style="list-style-type: none"><li>ОХУ</li><li>Орёл муж</li></ul>                   | 2019.11.11        | 2019.11.03     | Ойд  | 4 зэрлэг гахай |                |
| ДМАЭМБ     | <ul style="list-style-type: none"><li>Латви улс</li><li>Олайн тосгон</li></ul>         | 2019.11.11        | 2019.11.08     | Ойд  |                | 1 зэрлэг гахай |
| ДМАЭМБ     | <ul style="list-style-type: none"><li>Унгар улс</li><li>Borsod-Abauj-Zemplen</li></ul> | 2019.11.13        | 2019.10.21     | Ойд  | 40 зэрлэг гаха | 1 зэрлэг гахай |

Эх сурвалж: ДМАЭМБ

## MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын Эрүүл Мэндийн Яамны 46 дугаар долоо хоногийн эргэн мэдээллээр MERS-CoV-ийн халдварын сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Жеддах хотод амьдардаг. 75 настай, эрэгтэй. Халдвартай тохиолдолтой хавьтал болсон өгүүлэмжгүй байна.

Эх сурвалж: Promed.mail.org